

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙГ ОГЦРУУЛАХ  
ТУХАЙ АСУУДЛААР ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар  
сарын 18 -ны өдөр

Улаанбаатар  
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн  
Б.Гарамгайбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн гишүүдээс 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярыг огцруулах тухай асуудлыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярыг огцруулах асуудлыг дэмжих боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярыг огцруулах тухай асуудлаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ГАРАМГАЙБААТАР**